



The Alpha Mongols

NextGen **CELEBRATIONS!** Mongolia

ТОВХИМЛЫН ДУГААР №3

2024 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР

ТОВХИМЛЫН АГУУЛГА!

- Төслийн багийн шинэ гишүүдийн танилцуулга
- СЭМҮТ-тэй хамтран судалгааны ажлыг эхлүүлэх гэрээ байгууллаа
- Хүн төвтэй загвар /уулзалт сургалтууд/
- Ёс зүйн хорооноос судалгаа хийх зөвшөөрлөө хүлээн авлаа
- Хүний оролцоотой судалгааны ёс зүйн болон арга зүйн сургалт зохион байгууллаа



Төслийн багийн шинэ гишүүдийн танилцуулга

Сайн байна уу? Намайг Оюунзул гэдэг. Би Альфа үеийнхэн буюу Халдварт бус өвчнөөс сэргийлэх төслийн багийн шинэ гишүүн байна. Нийгмийн эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны хувьд, миний гол баримтлал бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь хамгийн сайн эмчилгээ гэж үздэг. Бид маш олон өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой байдаг нь үнэхээр гайхалтай хэдий ч дэлхий нийтээрээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чадахгүй байснаас олон



А.Оюунзул
Эрүүл мэндийн мэргэжилтэн

өвчинд нэрвэгдсээр л байна. Нийгмийн эрүүл мэндийн салбарт ажиллах нь миний хувьд хамгийн сонирхолтой, зүрх сэтгэлээ зориулан ажиллахыг хүсдэг салбар минь төдийгүй өөрийн чадах бүхий л зүйлээрээ энэ салбартаа хувь нэмрээ оруулан ажиллаж байгаадаа туйлын баяртай байна. Хамтдаа бид сайн өөрчлөлтийг түгээж, нийгмийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх зорилтууддаа хүрч чадна гэж итгэж байна.

Цаашид хийгдэх ажлууд

1. Суурь судалгааны мэдээлэл цуглуулах:

- Оролцогчид: 655 өсвөр үеийнхэн, 655 эцэг эх болон зорилтот 4 сургуулийн багш нар хамрагдана
- Судалгаа авах хүмүүс: Ойролцоогоор 20 бэлтгэгдсэн судлаач нар
- Чиглэл: Өсвөр үеийнхэн болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нарын Халдварт бус өвчлөлөөс үүдэн учирч болох эрсдэлүүдийн талаарх ойлголт, хандлага, туршлага мэдлэгийг үнэлэх
- Судалгааг эхлүүлэхээр төлөвлөж буй хугацаа: 4 сарын 8.

2. Саад бэрхшээлийн судалгаа:

- Оролцогчид: Зорилтот 4 сургуулийн 12-15 насны 450 сурагч
- Аргачлал: Эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, архи тамхины хэрэглээ, сэтгэлзүйн эрүүл мэндийн талаар ганцаарчилсан ярилцлага хэлбэрээр судалгаа явуулна
- Судалгааг эхлүүлэхээр төлөвлөж буй хугацаа: 4 сарын 8.



СЭМҮТ-тэй хамтран төслийн судалгааг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурлаа

АДРА Монгол ОУБ, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, АНУ-ын Нийгмийн Эрүүл мэндийн Лома Линда Их Сургууль болон АДРА ОУБ хамтран “Улаанбаатар хотын зорилтот сургуулиудын 12-15 насны өсвөр үеийнхний эрүүл мэнд, эрүүл зөв дадлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эрүүл сургалтын орчныг бүрдүүлэх” төслийн хэрэгжилтийн судалгааг хийж гүйцэтгэх хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа. АДРА Монгол байгууллагын хэрэгжүүлж буй “Альфа үеийнхэн” буюу Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх төсөл маань 12-15 насны хүүхдүүдэд эрүүл амьдралын хэв маяг, зан төлөвийг эзэмшүүлэхэд чиглэсэн төслийн зорилт, нөлөөллийн ажлыг тодорхойлон гаргаж ирэхэд энэхүү судалгааны ажил чиглэгдсэн болно. Энэхүү судалгаа нь төсөл үргэлжлэх хугацаа буюу 3 жилийн хугацаанд үргэлжлэх болно. 2023 оны 11 сарын 13-нд Эрүүл Мэндийн Яамны дэргэдэх Анагаах Ухааны Ёс Зүйн Хяналтын Хорооноос судалгааны ажлыг хийх арга зүйн талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүний дараа судалгаа хийх Ёс Зүйн зөвшөөрлийг гардууллаа.



Хүн төвтэй загвар / Уулзалт сургалтууд /

Төслийн төлөвлөгөөний дагуу Налайх дүүргийн “Эрдмийн Оргил” сургууль, Сонгинохайрхан дүүргийн “Хөгжил цогцолбор” сургууль болон Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургуулиудад 5 удаагийн уулзалт, сургалт зохион байгууллаа. Уулзалтын зорилго нь өсвөр насны хүүхдүүдэд чиглэсэн хөтөлбөр боловсруулахын тулд “хүн төвтэй загвар” ашиглан тэдний хэрэгцээ шаардлагыг илрүүлэх юм. Нийтдээ 60 хүүхэд хамрагдсан ба хүүхдүүд Сонголт, Дасгал хөдөлгөөн, Тэсвэр тэвчээр, Өөдрөг үзэл, Шим тэжээл болон Нийгмийн дэмжлэг гэсэн сэдвүүдийн хүрээнд өөрсдийн үзэл бодлоо хуваалцлаа.



ЭМЯамны дэргэдэх АУ-ны Ёс Зүйн хяналтын хорооноос төслийн судалгааг хийх зөвшөөрлөө авлаа

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хийгдэж байгаа томоохон ажлуудыг та бүхэнтэй хуваалцаж байгаадаа баяртай байна. Төслийн баг ЭМЯ-ны дэргэдэх АУ-ны Ёс Зүйн Хяналтын Хороо болон АНУ-н НЭМэндийн Лома Линда Их Сургуулиас судалгаа хийх албан ёсны зөвшөөрлөө авсан. Энэхүү зөвшөөрлийг авснаар суурь судалгаагаа амжилттай хийж, судалгааны ёс зүйн хэм хэмжээг баримтлан цаашид төслөө амжилттай хэрэгжүүлэхэд түлхэц болно гэж итгэн байна. “Өсвөр насны хүүхдүүдэд ээлтэй сургуулийн орчин бүрдүүлэх, улмаар 12-15 насны өсвөр үеийн хүүхдүүдэд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх” нэртэй судалгааны ажил нь АДРА Монгол ОУБ, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв болон Америкийн Нэгдсэн Улсын Нийгмийн Эрүүл Мэндийн Лома Линда Их Сургуулиас хамтран хийж байгаа судалгаа юм. Судалгааны багт ажилд нь илүү их амжилт хүсье. Судалгааны ажлыг 2024 онд хийж, харин 2026 оны хавар үнэлгээ хийгдэх болно.

Хүний оролцоотой судалгаанд баримтлах ёс зүй ба санал гомдлыг шийдвэрлэх арга зүйн сургалт зохион байгуулагдлаа

12-15 насны өсвөр үеийнхний дунд эрүүл зөв дадал зуршлыг төлөвшүүлэх сургалтыг амжилттай зохион байгуулснаа та бүхэнтэй хуваалцаж байгаадаа баяртай байна. Мөн 2024 оны 2 сарын 19-22-ны хооронд “Судалгааны ёс зүй ба мэдээлэл цуглуулах арга зүй” сэдвийн хүрээнд бүтэн долоо хоногийн сургалтыг Цэцэг зочид буудалд зохион байгууллаа. Сургалтыг АДРА Монгол ОУБ болон Лома Линда Нийгмийн Эрүүл Мэндийн Их Сургуулийн судлаач Жиа Хернандез нар удирдан, амжилттай зохион байгууллаа. Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн төлөөлөгчдөөс бүрдсэн нийт 30 хүн сургалтад идэвхтэй хамрагдлаа. Сургалтын төгсгөлд оролцогч бүр Лома Линда Нийгмийн Эрүүл Мэндийн Их Сургууль болон АДРА Монгол байгууллагаас сертификат гардан авсан. Төсөл хэрэгжих зорилтот сургуулиудын өсвөр насны хүүхдүүдээс 12 сурагч, мөн 12 эцэг эхийн төлөөллийг сургалтын сүүлийн өдөр урин авчирч туршилтын судалгаанд хамрууллаа.



Follow us on social media to stay connected: Facebook Page **ADRA Mongolia** and Facebook Group - **NextGen CELEBRATIONS! Mongolia - "Альфа үеийнхэн"** for regular updates on our progress.

You can also check our website www.adra.org.mn. We extend our heartfelt thanks to our early supporters, donors, and partners who are making this project possible. If you have any questions about our project, please contact us!





Alpha Mongols

